



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/319

Номгон

Г Иргэн С.Бурмаа, Х.Одончимэг нарт
газар эзэмшүүлэх тухай


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн “Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай” 81 дүгээр тогтоолын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сум, Номгон 1 дүгээр баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-5, 508а тоот хаягт байрлах 17 дугаар байрны өргөтгөлийн зориулалтаар иргэн С.Бурмаагийн (ВЭ64091526) эзэмшихийг хүссэн 49 м2, Номгон 1 дүгээр баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-5, 508г тоот хаягт байрлах 17-р байрны өргөтгөлд үйлчилгээ явуулдаг иргэн Х.Одончимэгт (ВЮ69012901) үл хөдлөх хөрөнгийн доорхи 69 м2 газрыг тус тус дуудлага худалдааны анхны үнийг 2 дахин өсгөн нөхөн төлбөр төлүүлж, худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээ хэсэгчлэн шилжсэнтэй холбогдуулан эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн “Э” дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг газар эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

621010837